



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A/815

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Жаргалант сумын Баатархайрхан багт байрлах үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай "Вестерн холд" ХХК /4065115/-ийн эзэмшлийн 6000.0 метр квадрат газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 700.0 метр квадрат газрыг "Номинреалтор" ХХК /5638771/-д хаягыг Эрх чөлөө 2 дугаар гудамжны 202 б тоот болгон 6 жилийн хугацаагаар, үлдсэн 5300 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 5124.0 метр квадрат, хаягыг Эрх чөлөө 2 дугаар гудамжны 202 тоот болгон "Вестерн холд" ХХК /4065115/-д үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 жилийн хугацаагаар тус тус шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖКАВ



Zax A/815 Ch  
02 04001